



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот


О.Батмөнхийг сургалтанд хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дани улсын Копенгаген хотод зохион байгуулагдах “Улаанбаатар хотын дулааны техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа”-ны сургалтанд тус албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Очирбатын Батмөнхийг 2019 оны 03 дугаар сарын 18-наас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. О.Батмөнхөд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг мэргэжилтэн О.Батмөнхөд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

